



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 1/283

Номгон

Г Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг
ослын үеийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд
шилжүүлж, стратегийн команд штабын
дадлага, сургуульд бэлтгэл ажлыг хангуулж,
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 зүйлийн 27¹.1.4, 27¹.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.5, 32.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 тогтоолын хавсралтаар батлагдсан 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.7 дугаарт заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын өрөнхий газартай хамтран Улсын хэмжээнд зохион байгуулах “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуульд оролцохтой холбогдуулан аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг ослын удирдлагын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж нэгдүгээр хавсралтаар, стратегийн команд штабын дадлага, сургуулийн шуурхай штабын үйл ажиллагааны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын хэмжээнд зохион байгуулагдах “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуульд аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж, идэвх оролцоо, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Онцгой комиссын нийт гишүүд, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн дарга нарт;

3. “Стратегийн команд штаб”-ын дадлага, сургуулийн хүрээнд гамшгийн аюулын зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага, сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт Улсын хэмжээнд зохион байгуулах тул иргэд амьдардаг орчныхоо “Аюулгүй цэг”-т, аж ахуйн нэгж, байгууллагууд тусгай тэмдэглэгээ бүхий “Түр цугларах цэг”-т тус тус холбогдох зааврын дагуу гарч дадлага, сургуулилт хийхийг

642310701


иргэд, аж ахуй нэгж, байгууллагын дарга, удирдлага, аймгийн Онцгой комиссын гишүүд, сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;


4.Дадлага, сургуулийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад газар хөдлөлтийн гамшигийн аюулыг таниулах “Бэлэн бай” аян, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага, сургуулийг хийхтэй холбогдсон мэдээлэл, сурталчилгааны хэвлэмэл болон видео шторкуудыг Гамшигаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3(Гамшиг болон аюулын дохио, сээрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй)-т заасны дагуу тухай бүр үнэ төлбөргүй, өдөр бүр олон удаагийн давтамжтайгаар иргэд, олон нийтэд шуурхай хүргэж, сурталчилж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээллийн алба(Д.Дэлгэрсайхан), Баянхонгор телевиз(захирал Б.Батбаатар), Номгон телевиз (захирал Д.Амгаланбаатар), Өнөөгийн Баянхонгор сонин(эрхлэгч П.Санаадагва), Баянхонгор таймс(эрхлэгч С.Гантулга), Есөн-Эрдэнэ зах(захирал Г.Амараа) нарт;

5.Дадлага, сургуульд оролцох аймаг, сумдын Онцгой комисс, гамшигаас хамгаалах албад, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүнийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын Нарийн бичгийн дарга (дэд хурандаа Б.Мягмарсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

6.Стратегийн команд штабын дадлага сургуулийн шуурхай штабын үйл ажиллагааны зардал болох 2,261,000 (Хоёр сая хоёр зуун жаран нэгэн мянган) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын удирдлага, зохион байгуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.





Аймгийн Засаг дартын ... дугаар сарын-ний
өдрийн дугаар эзжирэмжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ОСЛЫН УДИРДЛАГЫН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ

Д/д	Нэгжийн нэр	Албан тушаалтан	Гүйцэтгэх чиг үүрэг
1	2	3	4
1. Онцгой комиссын шуурхай штаб төв			
1.1	Ослын үеийн удирдагч	Аймгийн Засаг дарга;	Гамшиг, ослын үеийн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийх, багуудын харилцан ажиллагаа, уялдаа холбоо, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах
1.2	Ослын үеийн удирдагчийн орлогч	Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын гамшигийн үеийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан орлогч;	Удирдлагаас гаргасан бүх төрлийн шийдвэрийн хэрэгжилтийг бүх шатанд хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага байхгүй тохиолдолд үйл ажиллагааг орлож хариуцан зохион байгуулах
1.3	Олон нийтийн мэдээллийн хариуцсан гишүүн	Аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб хариуцсан орлогч;	Багийн ахлагчаас албан ёсны зөвшөөрөл авч иргэд олон нийтийг ослын үеийн бодит мэдээ, мэдээллээр хангах
1.4	Холбогч ажилтан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;	Багуудын бүх төрлийн шийдвэр болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авч, багийн ахлагч, гишүүдийг тасралтгүй мэдээллээр тогтмол хангах
1.5	Аюулгүй байдлын хариуцсан гишүүн	Тагнуулын хэлтсийн дарга;	Гамшиг, ослын үед багуудын харилцан ажиллагааны мэдээллийн болон ажиллагааны үеийн аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих
2. Ажиллагааны баг			
2.1	Ажиллагааны багийн удирдагч	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга;	Гамшиг, ослын үеийн нөхцөл байдлын үед тактикын бүх ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах

1	2	3	4
2.2	Орлогч дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга;	Багийн ахлагчид бүх төрлийн тактикин ажиллагаа явуулхад туслах, мөн багуудын харилцан ажиллагаа хангах
2.3	Хууль, эрх зүйн асуудал хариуцсан гишүүн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;	Гамшиг, ослын үеийн нөхцөл байдлын үед тактикин бүх ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсхэд хяналт тавих, чиглүүлэн, заавар зөвлөмжээр хангах
2.4	Нийгмийн асуудал хариуцсан гишүүн	бодлогын хариуцсан	Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга; Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайл бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнө болон сургуулийн настын хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах; Гамшиг, ослын үед ёндер настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний эзлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
2.5	Олон нийтийн аюулгүй байдал, хэв журам хариуцсан гишүүн	Цагдаагийн газрын дарга; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга;	Гамшиг, ослын үед нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах
2.6	Цар тахал, гоц халдварт өвчин, хорио цээр хариуцсан гишүүд	Нэгдсэн эмнэлгийн дарга;	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдварт эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах,
2.7		Зоонозын өвчин судлалын төв;	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах

1	2	3	4
			Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдвартгүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах
2.8	Эрчим хүч хариуцсан гишүүн	“Баянхонгор- Эрчим хүч” ЦТТӨХК-ийн дарга;	Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугаманд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
2.9	Цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ хариуцсан гишүүн	“Чандмань-Баянхонгор” ХК-ийн захирал;	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх; Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах
2.10	Харилцаа, холбоо зарлан мэдээлэл хариуцсан гишүүн	“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн салбарын дарга;	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшигаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах
2.11	Олон Улсын хүмүүнлэгийн тусlamж, сайн дурын хэсэг хариуцсан гишүүн	Улаан загалмайн хорооны дарга;	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах;
2.12		Соёл урлагийн газар;	Гамшигийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Олон Улсын хүмүүнлэгийн тусlamжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
2.13	Механижуулсан хэсэг хариуцсан гишүүн	Зэвсэгт хүчиний 339 дүгээр ангийн захирагч;	Гамшиг, ослын үеийн барилга байгууламжийн томоохон хийц, бүтээц, далан суваг, шууд, аврах зам гарц гаргах, хоёр дахь эрсдэлээс урьдчилан сэргийлэх

1	2	3	4
2.14	Уул, уурхай, хүнд үйлдвэрлэл хариуцсан гишүүн	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга;	
2.15	Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан гишүүн	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;	Гамшиг, ослын үеийн хүүхэд болон эрсдэлт бүлгийн хамгааллын асуудлыг хариуцаж, үйл ажиллагаа зохион байгуулах
2.16	Хүнсний нөөц, хангарт хариуцсан гишүүн	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;	Гамшиг, ослын үеийн хүнсний бүх төрлийн хангамжийн асуудлыг хариуцан шийдвэрлэх
2.17	Нүүн шилжих, нүүлгэн шилжүүлэх болон түр орон байр хариуцсан гишүүн	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга;	Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах, Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргodoх байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлэх, нөөц бурдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах
3. Төлөвлөлтийн баг			
3.1	Төлөвлөлтийн багийн дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;	Гамшиг, ослын үеийн хүч хэрэгсэл, тооцоо, судалгаа, ажиллагааны төлөвлөлтийг хариуцах
3.2	Бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан гишүүн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;	Гамшиг, ослын үеийн барилга байгууламжийн томоохон хийц, бүтээц, далан суваг, шуудуу, аврах зам гарц гаргахад мэдээллээр хангах
3.3	Эрүүл мэндийн асуудал хариуцсан гишүүн	Эрүүл мэндийн газрын дарга	Гамшигийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах; Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах; Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бурдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион

1	2	3	4
			<p>байгуулах;</p> <p>Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусlamжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах;</p> <p>Зоонозын өвчинөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах, зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдвартгүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах</p>
3.4	Мал, амьтны гоц халдварт өвчин хариуцсан гишүүн	Мал эмнэлгийн газрын дарга;	<p>Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдвартын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдвартгүйтгэлийн арга хэмжээг холбогдох дурэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх</p>
3.5	Цаг агаарын болон химийн аюулыг үнэлж мэдээлэх асуудал хариуцсан гишүүн	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга;	<p>Гамшиг, ослын үеийн үйл ажиллагаанд цаг агаарын нөхцөл байдлын урьдчилсан болон сээрэмжлүүлэг мэдээллийг багуудад тухай бүр шуурхай хүргэж, тогтмол мэдээллээр хангах</p>
4. Санхүү, ар тал хангалтын баг			
4.1	Санхүү, ар тал хангалтын багийн дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;	<p>Гамшиг, ослын үеийн үйл ажиллагаанд шаардагдах санхүү, ар тал хангалт, нөөц татан төвлөрүүлэх асуудлыг хариуцан шийдвэрлэх, ослын үеийн шуурхай штаб, төлөвлөлтийн багуудыг холбогдох чиглэлээр мэдээллээр хангах</p>
4.2	Бүх шатны боловсролын асуудал хариуцсан гишүүн	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга;	<p>Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх,</p>
4.3	Эрсдэлт бүлгийн халамжийн асуудал хариуцсан гишүүн	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга;	<p>Гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах,</p>
4.4	Аймгийн ёвс, тэжээлийн аюулгүйн нөөц хариуцсан гишүүн	Сум дундын ойн ангийн дарга;	<p>Хүмүүнлэгийн тусlamжийн мэргэжлийн ангитай хамтран</p>

1	2	3	4	
		нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах		
5. Тээвэр зохицуулалт, ложистикийн баг				
5.1	Тээвэр зохицуулалт, ложистикийн багийн дарга	Авто тээврийн төвийн дарга;	Гамшиг, ослын үед ажиллаж байгаа багуудыг ложистикийн мэдээллээр хангах, үйл ажиллагааг тасралтгүй байхаар бүх төрлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтар хангах	
5.2	Орон нутгийн ачаа тээврийн нэгдсэн сүлжээ, ложистикийн хариуцсан гишүүн	“Рөүд мастер” ХХК-ийн орон нутгийн төлөөлөгч А.Өлзийжаргал;	Гамшиг, ослын үед багуудын үйл ажиллагаанд шаардлагатай автомашин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, шатахуун, хоол хүнс, Олон Улсын хүмүүнлэгийн тусlamжийн тээвэр, зохицуулалтыг хариуцан тасралтгүй байхаар шуурхай зохион байгуулах	
5.3	Орон нутаг, хот хоорондын тээвэр зохицуулалт хариуцсан гишүүн	Авто тээврийн хяналтын улсын байцаагч Ч.Амармэнд		
5.4		Сумдын дарга нар		

_____оо_____



Аймгийн Засаг дарга-ийн дугаар сарын-ний
өдрийн дэлхийн дараахирамжийн 2 дугаар хавсралт

**СТРАТЕГИЙН КОМАНД ШТАБЫН ДАДЛАГА СУРГУУЛИЙН
ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

Д/д	Материалын нэр	Шаардагдах хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хулдаасан хэвлэл (3*4)	2 ширхэг	160,000	320,000
2	Хулдаасан хэвлэл (2x3)	1 ширхэг	81,000	81,000
3	Хөлтэй слайд	5 ширхэг	25,000	125,000
4	Слайд	5 ширхэг	35,000	165,000
5	Принтерийн хор	4 ширхэг	65,000	260,000
6	Бичгийн цаас	20 боодол	20,000	400,000
7	Ослын удирдлагын нэгдсэн тогтолцоо (гарын авлага)	35 ширхэг	20,000	700,000
8	Онцгой комиссын гишүүдийн ширээний нэр тогтоогч (Name plate)	35 ширхэг	6000	210,000
9	Нийт дүн			2,261,000

-----000-----

Г.Энхбаяр (Баянхонгор сумын Засаг дарга)

(Сумдын Засаг дарга нар)


Нарийн бичгийн дарга

Л.Мөнхцацрал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга)

2. Орон нутагт мэдээлэл цуглуулах тоологчдод газарчлах, судалгаанд хамруулах өрхүүдэд саадгүй очих ажлыг шуурхай зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт, судалгааны багийн ажилтнуудыг гэмт халдлагад өртөх, гэмтэж бэртэх эрсдэлээс сэргийлэх чиглэлийг сумын Хэсгийн цагдаа, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад өгч ажиллахыг Б.Мөнхбаяр (Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа), сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө батлуулан, төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагчид, гэрээт ажилтан, тоологч, хөтөч нарт чиглэсэн сургалтыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Судалгааны ажлыг шуурхай зохион байгуулахад нэгдсэн удирдлага арга зүйгээр ханган, байнгын ажиллагаатай ажиллаж, захирамжийн хэрэгжилтийг хангахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Батсуурь)-л даалгасугай.





МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/259

Номгон

Г
Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн
ундны усны талаар авах зарим арга
хэмжээний тухай

Эрүүл мэндийн яамнаас улсын хэмжээнд 2022 онд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ундны цэвэр усны дээжид хийсэн лабораторийн шинжилгээний дүнгээр төвлөрсөн бус ус хангамжийн усны бохирдолын түвшин их, 10-аас дээш хувьд нь нянгийн ерөнхий тоо стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их, 2,2 хувь нь эмгэг төрөгч нянгийн бохирдолтой байгаа судалгаа гарсантай холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А/230/127 дугаар тушаалаар баталсан “Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын хэрэгжилтийг ханггуулж, шуурхай арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Сургууль, цэцэрлэгийн ундны цэвэр усны дээжид улирал тутам шинжилгээ хийж үр дүнг танилцуулж ажиллахыг Стандарт хэмжил зүйн хэлтэс (Н.Шагдарсүрэн), Бөөнцагаан -Оrog нуурын сав газрын захиргаа /Б.Ням-очир/-т холбогдох арга хэмжээ авч жил бүрийн 5, 10 дугаар сарын 25-ны дотор тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг), Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургууль, цэцэрлэгийн ундны усны шинжилгээний зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж, ажиллахыг сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6 + 175 7851

2.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

